

**АГУУЛГА**

<b>НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>3</b>
1.1. Төслийн талаарх мэдээлэл .....	4
1.2.Төслийн байршил .....	4
1.3.Орд ашиглах тусгай зөвшөөрөл .....	5
1.4.2025 оны төлөвлөгөө .....	5
1.5.Ил уурхайн үндсэн хэмжээсүүд .....	6
1.6.Уурхайн ажиллах горим.....	6
1.7. Уурхайн дотоод болон гадаргуугийн зам: .....	7
1.8. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд сонголт.....	7
1.9. Элс угаан баяжуулалтын хэсэг .....	8
1.11. Хүний нөөц.....	8
1.12. Дэд бүтэц .....	8
<b>ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>9</b>
2.1. Газрын гадарга, байрзүй .....	9
2.2. Уур амьсгалын онцлог .....	10
2.3. Усан орчин .....	11
2.4. Хөрс.....	11
2.5. Ургамал.....	11
2.6. Нийгэм эдийн засаг .....	11
<b>ГУРАВ.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....</b>	<b>13</b>
<b>ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....</b>	<b>14</b>
<b>ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>15</b>
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	15
5.2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	17
5.3.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
5.4.Тэрбум мод төслийн хүрээнд .....	18
5.5.Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө .....	18
5.7.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	18
5.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	19
5.9.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	20
5.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	22

5.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах.....	24
5.12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	25
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>26</b>

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	4
Хүснэгт 2. MV-019638 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол:.....	4
Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим .....	6
Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн жагсаалт .....	7
Хүснэгт 5. Элс угаан баяжуулах хэсгийн үндсэн тоног төхөөрөмжүүд .....	8
Хүснэгт 6.Төслийн нийт ажилчдын тоо .....	8
Хүснэгт 7. Барилга, байгууламжийн мэдээлэл.....	8
Хүснэгт 8. Нийт ашиглах усны хэмжээ.....	9
Хүснэгт 9. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шалгуурууд ба сөрөг нөлөөлөл үүсч болох шалтгаанууд .....	13
Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	15
Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	17
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд нөхөн сэргээлт хийх газрын солбилцол.....	<b>Error! Bookmark not defined.</b>
Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	20
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
Хүснэгт 16. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	24
Хүснэгт 17. 2025 оны БОМТ-ний нийт зардал.....	25

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг1.Төслийн талбайн байршлын зураг.....	4
--	---

## ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хагаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг буурцуулах, арилгах, урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөргө үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөн нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах зүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Ирмүүн босго” ХХК нь мөрдөж ажиллана.

“Шинээгийн ам болон жалга-3”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхийл сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдснөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

### **БОМТ боловсруулах ара аргачлал:**

“Ирмүүн босго” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Шинээгийн ам болон жалга-3”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь өмнөх жилүүдэд бүрэн хүчин чадлаар ажиллаж чадаагүй, ордын нөөцийг бүрэн ашиглаж дуусаагүй байгаа тул 2025 онд уурхайн хаалт хийгдэхгүй. Иймд төслийн БОННУ-ний тайлангийн хаалтын өмнөх жилийн менежментийн төлөвлөгөөг урьтал болгон 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тус төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Ирмүүн босго” ХХК-ийн хэрэгжүүлэх “Шинээгийн ам болон жалга-3”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны БОМТ-нд нийт 65.08 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

## НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн талаарх мэдээлэл

**Газар зүйн байршил:** “Ирмүүнбосго” ХХК-ийн MV-019638 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт Бумбат-6 нэртэй газар оршино.

Засаг захиргаа: Төв аймаг Заамар сум

Ордын нэр: “Шинээгийн ам” (хш-02-с хш-14), “Жалга-3” (хш-02-с хш-8) алтны шороон ордууд (цаашид “Шинээгийн ам болон Жалга-3 алтны шороон орд” гэх)

**Ашигт малтмалын үндсэн төрөл:** Алт

**Тусгай зөвшөөрлийн талбайн планшит:** М-48-138

**Тусгай зөвшөөрлийн талбайн нийт хэмжээ:** 515.06 га.

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл*


№	Үзүүлэлтүүд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Ирмүүн босго” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	9011244141
3	Уурхайн нэр	Шинээгийн ам болон жалга 3 алтны шороон орд
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг
5		Сум/Дүүрэг
6	Ашигт малтмалын төрөл	алт
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-019638
8	Ашиглалт эхэлсэн огноо	1992
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот
10		Сум/Дүүрэг
11		Баг/Хороо
12		Гудамж/Байр
13		Тоот
14	Захирлын хаяг	Нэр
15		Гар утас

### 1.2.Төслийн байршил

“Ирмүүн босго” ХХК-ийн MV-019638 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун хойш 220 км, Заамар сумын төвөөс баруун хойд зүгт 25 км-т байрлана.

*Хүснэгт 2. MV-019638 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол:*

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104° 32' 06.14"	48° 19' 41.82"	13	104° 33' 19.19"	48° 19' 10.61"
2	104° 30' 59.00"	48° 19' 41.81"	14	104° 33' 14.33"	48° 19' 10.58"
3	104° 30' 59.00"	48° 19' 40.00"	15	104° 33' 14.26"	48° 19' 18.68"
4	104° 31' 24.00"	48° 19' 40.00"	16	104° 33' 09.40"	48° 19' 18.67"
5	104° 31' 24.00"	48° 18' 40.00"	17	104° 33' 09.36"	48° 19' 23.51"
6	104° 32' 29.00"	48° 18' 40.00"	18	104° 32' 49.94"	48° 19' 23.44"
7	104° 32' 29.00"	48° 18' 23.00"	19	104° 32' 49.88"	48° 19' 29.91"
8	104° 33' 21.01"	48° 18' 23.00"	20	104° 32' 42.60"	48° 19' 29.88"
9	104° 33' 21.02"	48° 18' 56.82"	21	104° 32' 42.58"	48° 19' 33.13"
10	104° 33' 26.58"	48° 18' 56.82"	22	104° 32' 35.30"	48° 19' 33.10"
11	104° 33' 26.52"	48° 19' 04.15"	23	104° 32' 35.26"	48° 19' 36.33"
12	104° 33' 19.25"	48° 19' 04.14"	24	104° 32' 06.14"	48° 19' 36.31"



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

### 1.3.Орд ашиглах тусгай зөвшөөрөл

MV-019638: Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газраас “Ирмүүн босго” ХХК-д 515.06 гектар талбай бүхий уурхайн эдэлбэр газарт ашигт малтмал ашиглах эрхийг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр шилжүүлсэн байна.

### 1.4.2025 оны төлөвлөгөө

“Ирмүүн босго” ХХК нь 2025 онд Шинээгийн ам алтны шороон ордын С-3 блокийн үлдэгдэл нөөц болон С-4, С-5, С-6, С-7 блокуудаас 1.3 сая.м<sup>3</sup> хөрс хуулж 56.04 мян.м<sup>3</sup> элс олборлож химийн цэврээр 80.4 кг алт авна.

Блокний дугаар	Хөрс			Элс олборлолт	Уулын нул	Хөрс хуулалтын коэффициент	Дундаж агуулга	Металлын хэмжээ /Шлих/	Металлын хэмжээ /Хими цэвр/
	Шимт хөрс	Хоосон чулуулаг	Нийт хөрс						
Х.нэгж		мян.м <sup>3</sup>		мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	Кх.х	мг/м <sup>3</sup>	кг	кг
<b>Шинээгийн ам</b>									
С-4	2.11	372.85	374.96	21.85	396.80	17.16	1,427.31	31.18	26.54
С-5	2.15	364.22	366.37	12.02	378.40	30.47	1,268.86	15.26	12.98
С-6	3.05	407.17	410.22	12.14	422.36	33.80	2,268.11	27.53	23.42
С-7	1.35	202.46	203.81	5.82	209.63	35.00	2,815.65	16.40	13.95
С-3	-	12.00	12.00	4.21	16.21	2.85	977.67	4.12	3.50
<b>НИЙТ</b>	<b>8.67</b>	<b>1,358.69</b>	<b>1,367.36</b>	<b>56.0</b>	<b>1,407.19</b>	<b>24.40</b>	<b>1,685.89</b>	<b>94.48</b>	<b>80.40</b>

**Ил уурхайн процесс:** Шинээгийн ам алтны шороон орд нь тоног төхөөрөмжүүдээс хамааран уулын ажил дараах процессын дагуу явагдана.

*Хүснэгт №1. Ил уурхайн процесс*

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Автотээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Шимт хөрс түрж хуулах 1.2. Шимт хөрс ачих 1.3. Шимт хөрс тээвэрлэх 1.4. Хөрс ухаж ачих 1.5. Хөрс тээвэрлэх 1.6. Дотоод овоолгод асгах 1.7. Овоолго түрэх
	2. Олборлолт	2.1. Ухаж ачих 2.2. Тээвэрлэх 2.3. Овоолох (угаах)

**Шимт хөрс хуулалт:** Шинээгийн ам хэсгийн алтны ордын блокийн талбайн өргөн дунджаар 100 м тул шимт хөрсийг бульдозероор түрж овоолон утгуурт ачигч, автосамосвалын хослолоор овоолго үүсгэж хураана. Энэ шимт хөрсний овоолго нь 8.67 мян.м<sup>3</sup> байх ба 5 м өндөр 38<sup>0</sup> налуугаас хэтрүүлэхгүй, салхи үерийн усны нөлөө байх газрыг тооцож уурхайн хойд талд байгуулна. Шимт хөрсийг ил уурхай, гадаад овоолго, автозамын болон бусад барилга байгууламжийн суурийн талбайгаас 0.3 метрийн зузаантайгаар хуулна.

### 1.5. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

**Уул техникийн нөхцөл.** Ашигт малтмалын орд нь Шинээгийн ам болон Жалга-3 гэсэн хоёр тусдаа ордоос бүрдэх ба уул техникийн харьцангуй энгийн нөхцөлд оршдог.

**Жалга-3 орд** нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд талд байрлах ба уулын хажуу дээр орших бөгөөд элсний давхаргын унал нь зүүн хойноос баруун урагш чиглэлтэй 3-70 уналтай, өргөн нь 12-45 м дунджаар 30 м, урт нь 580 м сунаж тогтсон байна. Ордын хучаас хөрсний дундаж зузаан нь 13.8 м, элсний дундаж зузаан нь 0.7 м ба алтны дундаж агуулга нь 814 мг/м<sup>3</sup> байна.

**Шинээгийн ам** алтны шороон орд нь уулын энгэр тал газар орших бөгөөд элсний давхаргын унал нь баруунаас зүүн тийш чиглэлтэй 2-80 уналтай, өргөн нь 51-161 м дунджаар 106 м өргөнтэй, 550 м урт сунаж тогтсон байна. Ордын хучаас хөрсний дундаж зузаан 34.6 м, элсний дундаж зузаан 1.5 м ба алтны дундаж агуулга 2,268.69 мг/м<sup>3</sup> байна.

**Ил уурхайн ашиглалтын систем.** Орд нь уул техникийн хүндрэл харьцангуй бага юм. Эдгээр уул техникийн нөхцөл болон төсөл захиалагчийн өөрийн бэлэн байгаа техникийг үндэслэн ордыг ил уурхайн аргаар авто тээвэртэй, гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглахаар төслийг боловсруулсан байна.

### 1.6. Уурхайн ажиллах горим

Шинээгийн ам болон Жалга-3 ордын уурхай нь засвар үйлчилгээний хоногийг хасаж тооцсоноор цэвэр 80 хоног ажиллана.

*Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим*

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	103
2	Засвар үйлчилгээ	хоног	12
3	Бэлтгэл	хоног	11
4	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	80
5	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	24
6	Ээлжийн тоо	удаа	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	12

8	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх), цаг	цаг	1
9	Ээлжийн бэлтгэл, төгсгөл, цаг	цаг	1
10	Өдрийн сул зогсолт	цаг	4
11	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	20
12	Цаг ашиглалт	-	0.83
13	Жилд ажиллах нийт цаг	мөт/цаг	1600

### 1.7. Уурхайн дотоод болон гадаргуугийн зам:

Уурхайн карьер доторх автозамын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу хоёр урсгалтай, замын зорчих хэсгийн өргөн тооцоогоор 10.2 м байна. Уулын ажилд 10.0 м-ээр тооцов. Замын налуу 120° байна.

Хөдөлгөөнд оролцож буй автосамосвалуудын хоорондох зөвшөөрөгдөх зайг автосамосвалын хурднаас хамааруулан тооцоход 47.4 м, автосамосвалын хурд ба уртаас хамааралтайгаар тооцоход 37.8 м гарч байна. Хөдөлгөөнд оролцож буй автосамосвалуудын хоорондох зөвшөөрөгдөх зайг 45 м-ээр тооцов. Мөн уурхайн траншейн замын өргөн 10 м хоёр урсгалтай, элс тээвэрлэх зориулалттай замын өргөн 4.5 м өргөн нэг урсгалтай байна.

**Элс тээвэр.** Уурхайн элс тээврийг “Ирмүүн босго” ХХК-ийн эзэмшлийн MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрлах скруббер-1, 2-ын элсний түр овоолгын талбай хүртэл тээвэрлэнэ. Шинээгийн ам ордоос скруббер-1 хүртэл явах тээврийн зам нь 3.9 км, жалга-3 ордоос явахад 2.3 км байна. Энэ замын чиглэл нь орон нутгийн шороон зам ба скруббер-1-ээс скруббер-2 хүртэл шулуун шугамаар хэмжихэд хоорондоо 500 м зайтай байна. Элс буулгах талбайн байршлыг төсөл захиалагчийн техникийн даалгаварт тусгасны дагуу төслийг боловсруулсан байна.

### Баяжуулалтын хэсэг

Баяжигдах шинж чанарын технологийн туршилтад үндэслэн Шинээгийн ам болон Жалга-3 алтны шороон ордын элсийг гравитацийн аргаар баяжуулах хэсгийн төлөвлөлт, технологийн шат дамжлагуудын загварыг гаргасан.

Технологийн схемийн хувьд шлюз болон сэгсрэх ширээгээр баяжуулахад 0.25% -ийн гарцтай 14,961 гр/тн-ийн алтны агуулгатай 92.6%-ийн металл авалттай баяжмал гарган авсан байна. Иймд Геологийн төв лабораторийн санал болгосон схемээр тооцооллыг хийж гүйцэтгэлээ.

Ил уурхайн элс олборлолтын төлөвлөгөө болон захиалагчаас өгсөн ажлын даалгаврын дагуу элс угаан баяжуулах хэсгийг 2 хэсэгт “Ирмүүн босго” ХХК-ийн эзэмшлийн MV-000296 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хоорондоо 500 м-ийн зайтай өмнө ашиглаж байсан үүсмэл нуурыг түшиглэн байрлуулахаар төлөвлөсөн. Элс олборлолтын дараа үлдсэн орон зайд баяжуулах хэсгээс гарсан эфель, галийн хаягдлыг түрэх байдлаар нөхөн дүүргэхээр төлөвлөсөн.

### 1.8. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд сонголт

Төслийг захиалагч “Ирмүүн босго” ХХК нь өмнө ашиглаж байсан өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, техник хэрэгслэтэй бөгөөд өмнөх ашиглаж техник тоног төхөөрөмжөөр уулын ажлыг үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Хүчин чадал	Тоо, ширхэг
1	Экскаватор	Hyundai R850LC	5.4 м <sup>3</sup>	2
2	Экскаватор	Hyundai R520LC	3.2 м <sup>3</sup>	1
3	Автосамосвал	HOWO-371	50 тн	8

4	Бульдозер	CAT-D8	6.8 м <sup>3</sup>	2
5	Утгуурт ачигч	SDLG953	3.0 м <sup>3</sup>	4
6	Усны насос	Y280S	200 м <sup>3</sup> /цаг	6
7	Усны машин	HOWO	20 тн	1
8	Түлшний машин	Hyundai	8 тн	1
9	Аж ахуй үйлчилгээний машин	Land Cruiser 78 Long		2
10	Аж ахуй үйлчилгээний машин	Land Cruiser 76 Long		2
11	Аж ахуй үйлчилгээний машин	Pick up 79		1
12	Аж ахуй үйлчилгээний машин	Hiace		1
13	Крантай машин	Hino		1

### 1.9. Элс угаан баяжуулалтын хэсэг

Технологийн процесст том ширхэгийн элсний ангилалд сул алт хаягдахаас болгоомжилж баяжуулалтанд орж байгаа анхдагч бүтээгдэхүүний хамгийн том хэмжээг -20 мм-ээр сонгон авлаа. Дээжийг угаах, шигших үйлдлийг гар аргаар гүйцэтгэсэн байна. -20.0 мм-ийн ширхэглэлийн бүтээгдэхүүнийг лабораторийн туршилтанд хэрэглэдэг шлюзээр баяжуулж баяжмал болон хаягдал гэсэн 2 бүтээгдэхүүн гарган авчээ. Эдгээрээс гарсан баяжмалыг 2.0 мм-ийн шигшүүрээр шигшиж, торон дээрх бүтээгдэхүүний гар тэвш (лотки) ашиглан баяжуулж, том чөлөөт алт байгаа эсэхийг тодруулахаар минералогийн шинжилгээнд өгсөн байна. Харин шигшүүрийн нүхнээс доош гарсан бүтээгдэхүүнийг сэгсрэх ширээ (MODEL 15S)-гээр оруулан, баяжмалд ялгарсан хар шлихийг минералогийн шинжилгээнд өгч алтыг ялгуулан, алтанд шишүүрийн шинжилгээ хийлгэн, ангилал тус бүрийн жинг авсан болно.

Хүснэгт 5. Элс угаан баяжуулах хэсгийн үндсэн тоног төхөөрөмжүүд

№	7	Марк	Цахилгаан чадал, кВт
1	Скруббер	Шинээзеланд	21
2	Баяжуулах ширээ	СКО-4	1.1
3	Эргэлтийн усны насос	2BV2 071	3
4	Технологийн усны насос	2BV2 110	5.5
5	Цэвэр усны насос	2BV2 061	3
6	Дугуйт ачигч	Liugong ZL855	-

### 1.11. Хүний нөөц

Төслийн хүчин чадлыг эзэмших, түүнд хүрэхийг зорих хангалттай тооны ажилчдыг тусгаж өгсөн бөгөөд уулын хэсэг 2 ээлжээр ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг, баяжуулах хэсэг нь 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна.

Хүснэгт 6.Төслийн нийт ажилчдын тоо

№	Хэсэг нэгж	Ээлжинд	2 дахь жил
1	Төв оффис	3	3
2	Уулын хэсэг	57	57
3	Угаан баяжуулах хэсэг	28	28
4	Засвар механикийн хэсэг	8	8
5	Аж ахуй, үйлчилгээний хэсэг	16	16
6	<b>Нийт</b>	<b>112</b>	<b>112</b>

### 1.12. Дэд бүтэц

#### Барилга байгууламж

Уурхайн захиргаа, засвар үйлчилгээний төв зэрэг барилга байгууламжууд уурхайгаас 1.2 км зайд нийт 1.5 га талбайг эзлэн байрлана.

Хүснэгт 7. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
<i>Хотхон</i>				
1	Уурхайн удирдлагын байр	м <sup>2</sup>	56	Зөөврийн хаус



2	Ажилчдын сууц	ш	6	40 тн контейнер 6*29м <sup>2</sup>
3	Цайны газар	м <sup>2</sup>	40	Зөөврийн сууц
4	Хүнс ахуйн агуулах	ш	1	20 тн контейнер
5	Халуун ус болон угаалга	м <sup>2</sup>	40	Зөөврийн сууц
<b>Ил уурхай</b>				
6	Засварын газар, сэлбэгийн агуулах	м <sup>2</sup>	160	20 тн контейнер 2 ш, мөн сэндвич
7	Засварын талбай	м <sup>2</sup>	100	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна
8	Түлшний ёмкост	тн	110	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна

### Харилцаа, холбоо

Уурхайн тосгонд Мобиком, Юнител зэрэг үүрэн телефоны сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

### Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны хэрэглээг ДСЦТС ХХК-ний эзэмшлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын боломжит цэгээс салбарлан, тус уурхай хүртэл 500 м үргэлжлэх 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татсан, 6/0.4 кВ-т хүчдэлтэй 630 кВа-ын суурилагдсан хүчин чадалтай хаалттай дэд станцаас хангана.

### Аянгаас хамгаалах байгууламж

Аянгийн шууд цохилтоос хамгаалах зорилгоор аянга хүлээн авагч, гүйдэл зайлуулагч, газардуулгын голчтой савхан аянга зайлуулагчийг байрлуулан гүйцэтгэнэ. Аянга зайлуулагч нь өөр өөрийн газардуулгатай байна.

ШТМ-ын агуулах болон засварын талбай нь анхдагч болон хоёрдогч аянгийн цохилтоос хамгаалагдсан байна. Анхдагч аянгийн цохилтоос хамгаалах аянга зайлуулагч нь талбайгаас зайтай тусдаа газардуулгатай байна.

### Усан хангамж

Уурхайн унд ахуйн болон технологийн ус хэрэглээг 1.7 л/с ба 7.6 л/с ундарга бүхий 2 гүний худаг, 2 ш үүсмэл нуур (нуур-1 эзлэхүүн 112.8 мян.м<sup>3</sup>, нуур-2 эзлэхүүн 63.47 мян.м<sup>3</sup>)-аас хангана. Үүнд:

Унд ахуйн ус

1. Технологийн ус
2. Зам талбайн ус
3. Нөхөн сэргээлтийн ус

### Төслийн нийт ус хэрэглээ

#### Хүснэгт 8. Нийт ашиглах усны хэмжээ

Ажиллах жил	Шаардлагатай усны хэмжээ м <sup>3</sup>				
	Зам усалгаа	Угаан баяжуулах хэсэг	Нөхөн сэргээлт	Унд ахуй	Нийт
1 дэх жил	828.00	30,540.00		364.80	31,732.80
2 дахь жил	1614.60	125,628.00		880.08	128,122.68
3 дахь жил			20,096.0		20,096.00
Нийт	2,442.60	156,168.00	20,096.0	1,244.88	179,951.48

## ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Газрын гадарга, байрзүй

Хэнтийн нуруу ба түүний гол салбаруудын тойрог нь Хэнтийн гол нуруу, Бага Хэнтий, Их Хэнтийн нуруу, тэдгээрийн томоохон салбаруудыг багтаана. Эндхийн үнэмлэхүй өндөр нь 2000-2500 метр бөгөөд хамгийн өндөр цэг нь Асралт Хайрхан юм. Хэнтийн нурууд

ялангуяа Бага Хэнтийн нурууны хажуу нь хоорондоо адилгүй, хойт хажуу нь маш эгц бөгөөд урт, харин өмнө хажуу нь нилээн налуувтар болно. Гэвч хоёулаа нураг асгаар бүрхээстэй байна. Хажуугийн дээд хэсэгт шаталсан хэдэн дэнж тодорхой үзэгдэнэ.

Тойргийн хилийг тоймлон заавал: Зүүн талд Барах голын адаг орчмоор гарч өмнө хэсэгтээ Хурах, Туул голыг дагасан тектоникийн гаралтай хөндийнүүд болон Улаанбаатар хотоос нилээн хойгуур гарах ба баруун гар талдаа Хараа голын баруун гарын цутгалуудыг огтлон гарсан шугам, хойт талд улсын хил болно.

Голын хөндийнүүд хэдэн янзын дүрс хэлбэртэй юм. Гол нуруудын хөндий их төлөв нарийхан хавцлын байдалтай юм. Үүний зэрэгцээгээр тэнд бас хэдэн зуугаад метр өргөн хөндий ч бий. Тэр хөндийнүүдээр эртний мөсөн гол урсан бууж байсны ор мөр болох морены дов толгод, далан, дэнж, хаагдсан нуур тохиолдоно. Хэнтийн гол нуруудын захаар байгаа хөндийнүүд 1-3 км өргөн, хажуунууд мөн эгц болоод асгаар бүрхээстэй байна.

Энэ тойрог чийг тунадас ихтэй учраас намаг ихтэй, гол горхиуд усаар элбэг, уналт их, урсгал түргэн байдаг.

## 2.2. Уур амьсгалын онцлог

Төслийн талбай орчимд зуны улиралд эх газрын дулаан хуурай агаар зохнилдог. Иймээс орох хур тунадас ихэнхдээ аадар шинжтэй байдаг. Намар хур тунадас багасаж, цочир хүйтрэлт 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр ажиглагдсан 10 дугаар сарын сүүлч, 11 дүгээр сарын эхээр өвлийн нөхцөлдөө шилжин ордог.

Агаарын температур: Сүүлийн 60 шахам жилд энэ сав газрын агаарын дундаж температур  $2.0^{\circ}\text{C}$ -р дулаарсан байна. Дэлхийн уур амьсгалын дулааралтаар халуун өдрийн давтагдал нэмэгдэхийн хэрээр агаарын өндөр температур сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон байна. Сав газрын бараг бүх цаг уурын станц дээр 1940-өөд оноос хойш тохиолдсон хамгийн өндөр температур сүүлийн хэдхэн жилд тэмдэглэгдсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн манай орны уур амьсгалын эрс тэс байдал, цаг агаарын хүчтэй үзэгдлүүдийн давтагдал нэмэгдсээр байна. Тухайлбал хүснэгт 3-д байгаа агаарын температурын арав 10 жилийн явцаас харахад энэ районд сүүлийн жилүүдэд хүйтний улирлын температур буурч дулааны улирлын температур ихэссэн зүй тогтол ажиглагдаж байна. Харин жилийн дундаж утгаар бол 1992 оноос хойш ялимгүй  $0.01^{\circ}\text{C}$  орчим хэмээр хүйтэрсэн хандлагатай боловч 10 жилийн дунджаас үзэхэд  $0.1^{\circ}\text{C}$ -ээр хүйтэрсэн байна.

Салхи: Салхины хурдны жилийн явцад хавар, намрын улиралд 2 удаагийн максимум утга, өвөл, зуны улиралд 2 удаа минимум утга ажиглагдах бөгөөд хаврынх нь үндсэн их утга байх бөгөөд агаар, хөрс хамгийн хуурай үе, салины хүч хамгийн их үе хоёр давхцахаас болж жилд тохиолддог хүчтэй салхитай болон шороон шуургатай өдрийн тооны гол хувь нь зөвхөн хаврын саруудад тохиолдоно. Энэ районд 2012 оны 06 дугаар сарын 18 нд салхины хурд 26 м/с хүрч салхилж байжээ.

Хур тунадас: Туул голын сав газар Монголдоо ихээхэн чийглэг уур амьсгалтай, жилийн хур тунадасны нийлбэр нь 200-400 мм орчим байдаг. Өндөр уулын буюу гол мөрний урсац бүрдэх бүсэд 350 мм-ээс их хур тунадас жилд ордог бөгөөд хур тунадасны 85-90 орчим хувь нь жилийн дулаан улиралд ордог, хүйтэн улиралд хур тунадас тун бага ордог байдал харагдана. Хур тунадасны горимд дулааны улиралд хур тунадасны дотор аадар борооны эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа юм.

### 2.3. Усан орчин

Төслийн талбай нь Туул голын сав газарт орно. Сав газрын ихэнх нь Хэнтийн уулархаг бүсэд хамаарах ба цутгал голуудын дийлэнх нь Бага Хэнтийн нуруунаас эх аван урсдаг. Туул гол нь байгалийн бүс, бүслүүрийн хувьд эхэн хэсэгтээ уулын тайгын бүс, ойт хээрийн бүсийг дамнан урсах ба Улаанбаатар хотоос доош, сав газрын 80 гаруй хувийг эзлэх хээрийн бүсээр урсаж Орхон голд цутгана. Гол нь эхэн хэсэгтээ эгц хад хясаа болон ой мод элбэгтэй, уулсын 1-3 км өргөн хөндийтэй ба цаашид голын хөндий өргөссөөр Улаанбаатар хот орчимд 8-10 км болно.

### 2.4. Хөрс

Хөрс газарзүйн хувьд сав газрын хойд хэсэг нь Хэнтийн нурууны төв хэсгийн уулын тундрын болон уулын нугын хөрсний тойрогт, нутгийн дунд болон түүнээс хойш хэсэг нь Хэнтийн нурууны зүүн ба баруун хэсгийн салбар уулсын уулын хар хүрэн ба хээрийн хар хүрэн хөрсний тойрогт, өмнөд хэсэг нь хуурай хээрийн бүсийн ухаа гүвээт, уудам хөндийн хүрэн хөрсний тойрогт ордог.

Төслийн талбай нь гадаргын ерөнхий хэлбэр дүрсийн хувьд орой хэсгээрээ хадархаг нам уулс болон түүний энгэр, бэлийн системийг хамран төслийн талбайн байрших бөгөөд хөрсний үүсвэрийн үйл явцад хажуугийн зөөгдлийн үйл явц голчлон оролцох учир хөрс үүсгэгч эх чулуулаг нь алюви, делюви, пролювийн хайрган хурдас дээр тогтворжсон нимгэн ялзмагт давхаргатай, сайр чулуурхаг, нам ухаа толгод, уулын хөрс, тал газар, нам хөндий хотос газрын хөрс тархсан байна.

### 2.5. Ургамал

Хэнтийн нурууны чийглэг сэрүүн уур амьсгал, өндрийн бүс бүслүүр, говь, тал хээрийн бүсийн ялгаагаар ургамлын бүрхэвч өндөр уулнаас нам хотос хүртэл нэлээд ялгаатай бүрэлдэн тогтсон ба ургамлын бүтэц бүрэлдэхүүн Хангайн бүсэд баялаг, тал хээрт ядмаг байдаг байна. Сав газар нь тундрын, ойн, хээрийн, нугын хэв шинжийн ургамалшилтай юм.

### 2.6. Нийгэм эдийн засаг

Заамар сум нь УБ хотоос 180 км өөрийн аймгаас 225 км алслагдан оршдог бөгөөд Төв аймгийн Угтаал, Цээл, Лүн сумд, Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай сумд, Сэлэнгэ аймгийн Орхон туул сумдуудтай тус тус хиллэж нийт 280.3 мянган га нутаг дэвсгэрийг эзэлдэг.

Төв аймгийн баруун хойд хэсэгт: Улаанбаатар хотоос 180 км, Аймгийн төвөөс 225 км зайд байрладаг. Баруун талаараа Булган аймгийн Баяннуур Дашинчилэн сум, хойд талаараа Булган аймгийн Бүрэгхангай, Орхонтуул сум, Зүүн талаараа Төв аймгийн Цээл, Угтаал сум, Урд талаараа Төв аймгийн Баянхангай, Лүн сумдтай тус тус хиллэдэг.

Малын бүтэц: Сумын хэмжээнд 193631 толгой малтайгаас 170 тэмээ, 13788 адуу, 10674 үхэр, 94853 хонь, 74146 ямаа Сумын хэмжээгээр нийт 193,8 мянган мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 0,6 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 0,3 хувь байна. 437 малчин өрх, 650 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 67,2 хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсөв: Сумын төсвийн нийт орлого нь 4141,3 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт авдаггүй, сумын өөрийн орлого 1261,9 сая төгрөг төсөвт байгууллагын өөрийн орлого 1,9 сая төгрөг байна. Орон нутгийн нийт төсвийн зардал нь

2058,0 сая төгрөг байна. Нийт зардлын 61,4 хувь нь цалин, 6,8 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, хувийг урсгал шилжүүлэг болон бусад зардал эзэлж байна.

Эдийн засгийн бүтэц: Сумын хэмжээнд нийт 47 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 770,2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 30.6 сая, аймагт 203.4 сая, орон нутагт 56.0 сая нийт 209.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд жилд 230,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Заамар довон” ХХК 2900 га эргэлтийн талбайтай, 800 га д уриншийн боловсруулалт хийж жилд 1200,0 тн үр тариа хураан авдаг бөгөөд БӨЖТ зэрэг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлж байгаа нь тус сумын аж үйлдвэрийн бүтцэд томоохон нөлөө үзүүлж байна.

Сумын төвийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн өнөөгийн байдал: орон сууц, олон нийтийн бүс 1200 га ногоон байгууламж, хөдөө аж ахуйн бүс 240200 га хот суурингийн газар 81,0 га Өнөөгийн байдлаар 719 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 438 га газар өмчилж, 10 иргэн, аж ахуйн нэгж өвөлжөө, хаваржааны зориулалтаар 0,77 га газар, газар тариалангийн зориулалтаар 12700 га газар, 438 иргэн 8 аж ахуйн нэгж газар тариалангийн зориулалтаар эзэмшиж байна.

## ГУРАВ.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Хүснэгт 9. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шалгуурууд ба сөрөг нөлөөлөл үүсч болох шалтгаанууд

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд
<p><b>Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:</b> -Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх, -Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх.</p>	<p>Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий агаар орчныг бохирдуулна. Үүнд: -Хөрс хуулах, алт олборлох үед үүсэх тоос; -Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтат хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий, дуу чимээ; -Уурхайн олборлолт болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос; -Хөрс болон элс тээвэрлэх үед тээврийн хэрэгслийн дугуйнаас босох тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.</p>
<p><b>Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:</b> -Усны нөөцөд хомсдол үүсэх, эсэх, -Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх, -Ус бохирдуулах, эсэх.</p>	<p>Уурхай болон үйлдвэр технологийн хэрэгцээний усыг газрын доорх ус болон тунаах нуурын усаар хангана. Энэ тохиолдолд тунаах нуурын болон газрын доорх усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсгэх болно.</p>
<p><b>-Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө:</b> -Хөрс эвдрэх эсэх, -Хөрс бохирдох эсэх, -Хөрс доройтох эсэх.</p>	<p>Хөрсний морфологи бүтэц алдагдах, үржил шимт нөөц нь багасах, техногений нөлөөлөл ихсэж, олон салаа зам үүсч, хөрс эвдрэх, хөрс хийсэх, дарагдах, талхлагдах зэргээр шинж чанар нь өөрчлөгдөх, Хөрсний өнгөн хэсэг ахуйн хог болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох.</p>
<p><b>-Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө:</b> -Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх, -Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх.</p>	<p>Газарт бууж буй тоос нь ургамлын аль нэг хэсэгт наалдаж улмаар өнгө зүс нь алдагдах, навч нь эрт унах зэрэг байдал бий болдог байна. Ургамлын бүрхүүлийн энэхүү өөрчлөлт нь хүний нүдэнд ил харагдаж байдаг бол үүний цаана нүдэнд харагдахгүй ихээхэн өөрчлөлт орох, фотосинтезийн идэвхи буурах, өсөлт удаашрах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог.</p>
<p><b>-Ан, амьтанд үзүүлэх нөлөө:</b> -Амьтдын амьдрах орчинг доройтуулах эсэх, амьдрах орчинг үгүй хийх,</p>	<p>Алт олборлох үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин устах, жижиг амьтад үйл ажиллагаанд өртөж үхэж хорогдох, хүний үйл ажиллагааны улмаас амьтдын бүлгэмдэлд өөрчлөлт орох, улмаар зарим зүйл амьтдын тоо толгой, нүүдэл шилжилтэнд сөргөөр нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөтэй.</p>

## **ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

“Ирмүүн босго” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

### **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт**

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго шинээгийн ам болон жалга-3”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ундны усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээ,
- Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих, хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх,
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож, доор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэх.

## ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин						
1	- Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолтоос үүсэх тоосжилт,	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед услагаа хийх, салхи ихтэй үед тоос дарах арга хэмжээ авах	Уурхайн зам, талбай	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
2	- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, - Тээвэрлэлтэд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Тээврийн хэрэгсэл	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	-2010 MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага -MNS 4890:2000. ХААЭА. Ажлын байрны орчин, Эрүүл ахын шаардлага. -MNS 3383:1982. Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох
3		Тогтсон цэгүүдээс агаарын шинжилгээ тогтмол хийлгэх	Ил уурхай, кемп, овоолго	ОХШХ-ын зардалд тусгагдсан	Жилд 1 удаа	
Дуу чимээ						
4	-Чимээ шуугианы, физик бохирдол -Тээврийн хэрэгслээс гарах чимээ	Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах. Уг багажийг хэрэв БОШТЛ, “ОС МТ” ХХК зэргээс түрээслэвэл түрээсийн зардал нэг удаа 30000 төг	Уурхайн орчим	Шинжээчийн зардал ОХШХ-ийн зардалд тусгагдсан	Тогтмол Жилд 1 удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийнэ	-MNS 12.1.06:1988 Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын систем. Дуу чимээний хамгийн өндөр түвшин. Аюулгүй байдлын шаардлага. -MNS 12.4.005:1985 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа. Дуу чимээнээс хамгаалах багажийг ашиглах арга
Газрын доорх ус						
5	-Газрын доорх урсацын горим алдагдах, бохирдох, -Шатах тослох материал алдагдсанаас газрын доорх ус бохирдох, үер усны гамшиг тохиолдох	Усны эх үүсвэрийг хамгаалах барьсан хашааг засварлах	Гүний худаг	100,000.0	Уурхайн ажил эхлэхийн өмнө	-Ус ашигласны төлбөр (2013 оны 327-р тогтоол ) -Усны тухай хууль, -Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль

Хөрсөн бүрхэвч						
7		Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах	Тээвэрлэлтийн зам	200,000.0	Уурхайн ажил эхлэхийн өмнө	-MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага. -MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын эрүүл ахуйн үзүүлэлтүүд -MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ -MNS 4601:2011 Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүн. Техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо -Хог хаягдлын тухай хууль, -Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,
8	-Техник болон хүний нөлөөгөөр хөрс элэгдэл эвдрэлд өртөх, -Шатах тослох материал асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах, - Машин техникийн олон салаа зам үүсч тоос шороо үүсгэх, ургамал сүйтгэх, хөрсийг халцлах, -Хөрс хатуу хог хаягдлаар бохирдох	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Шимт хөрсний овоолго	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
9		Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, уурхайн орчинд асгарч алдагдахаас сэргийлэх	ШТМ-ын сав	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	
10		Тээврийн замыг засаж сайжруулах	Тээврийн зам	200,000.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
11		Талбайн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй байх, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх	Уурхай орчмын хог хаягдлын цэг	Хог хаягдлын төлөвлөгөөнд орсон	Тогтмол	
Ургамал						
12	-Олборлолт, уурхайн засвар үйлчилгээ, уурхайд олон салаа зам үүссэнээс болж ургамлан бүрхэвч устгах, -Хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас болж ургамлан бүрхэвч бохирдох, халцрах.	ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож ургамлан нөмрөгийг бохирдохоос сэргийлэх	Уурхайд	Хөрсөн бүрхэвчийг хамгаалах төлөвлөгөөнд орсон	Уурхайн ажил эхлэхийн өмнө	-Ургамлын тухай хууль -MNS 5914:2008. БО. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт -MNS 5915:2008. БО. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал -MNS 5916:2008. БО. Үржил шимт хөрсийг хуулах шаардлага -Ургамал хамгааллын тухай /2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр/ - MNS 5918:2008. БО. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. техникийн ерөнхий шаардлага
		Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хог хаях нэгдсэн цэг байгуулах	Уурхайн талбайд	Хог хаягдлын төлөвлөгөөнд орсон	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	
Амьтан						
13	-Үйл ажиллагаа явуулсантай холбоотойгоор амьтны нөөц хомсдох,	Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хашаа хамгаалалт хийх	Уурхайн талбайд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн ажил эхлэхийн өмнө	-Амьтны тухай хууль /2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр/ -Ан агнуурын тухай



-Ухсан нүх суваг, шуудуунд мал, амьтан унах, -Олборлолтын үед мэрэгч, мөлхөгчдийн амьдрах орчин алга болж, тэнд үүрлэх шавьжууд устах.	Хууль бус агнуур хийхгүй байхад анхаарч, хяналт тавих	Ажилчдад	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	/2000 оны 05 дугаар сарын 05-ны өдөр /
<b>Нийт зардал</b>			<b>500,000.0</b>		

## 5.2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Техникийн нөхөн сэргээлт	3 га	23,194,704	2025 онд	MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5916:2008 Үржил шимт хөрсийг хуулах шаардлага
2	Биологийн нөхөн сэргээлт	5 га	25,020,870	2025 онд	MNS 5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
<b>Нийт зардал</b>			<b>47,254,286</b>		

## 5.3.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилт	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Нийт зардал, төг /2025 он/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх ёстой байдаг.	Төв аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас санал болгосны дагуу 2025 онд Дүйцүүлэх ажлын хүрээнд 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ	Өөрийн техникээр, дотоод төлөвлөлтөөр	2025 онд	Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу

#### 5.4.Тэрбум мод төслийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих төслийн хүрээнд Төв аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газраас санал болгосны дагуу нийт 5000 ш мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийхээр тусгаж өгсөн. Үүний зардалд үр, үрсэлгээ худалдан авалт, тарилт, арчилгаа, усалгаа гэх мэт бүх урсгал зардал багтсан дүнгээр нийт **10,000,000 төгрөг** төсөвлөв.

#### 5.5.Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Ашиглалтын талбайд малчин өрх, айл суурьшдаггүй. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө хийгдэхгүй болно.

#### 5.6.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. “Ирмүүн босго” ХХК нь биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

#### 5.7.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2025 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
2	сүлжээний гэмтэл, -Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр	Гал түймрээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл (галын дохиолол) болон гал гарсан тохиолдолд унтраах, хамгаалалтын багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах, дууссан галын хорыг цэнэглүүлэх	Уурхайн орчимд	-	-	1,000,000.0	Уурхайн үйл ажиллагааны явцад	тухай хууль -MNS 5390:2004, “ХАБЭА. Цахилгааны галын аюулгүй

3	гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж шаардлагатай газруудад байрлуулах	Уурхайн кемп орчимд	-	-	200,000.0	Уурхайн үйл ажиллагааны явцад	байдал. Ерөнхий шаардлага”
4	зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй,	Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Уурхайн удирдлага	-	-	-	Жил бүр	
5	Хэт их дуу чимээтэй орчинд сонсгол хамгаалах хэрэгсэлгүйгээр эсвэл уртасгасан цагаар ажиллах, тээврийн хэрэгсэлтэй удаан харьцсанаас анхаарал болгоомж сулрах, тээврийн хэрэгсэлд өртөх	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах (өлмийний хамгаалалттай түрийтэй гутал, хамгаалалтын нүдний шил, дуулга, тоосны маск, ажлын бээлий гэх мэт)	Уурхайн ажилчид	35		Үйл ажиллагааны зардлаар	Жил бүр	
6		Тээвэрлэлт хийхийн өмнө автомашинуудад үзлэг шалгалтыг хийж, тухайн автомашинд шаардлагатай бүх багаж хэрэгсэл, гал унтраагуур бүрэн бүтэн байгаа эсэхийг хянах	Уурхай орчимд		-	Үйл ажиллагааны зардлаар	Тогтмол	
7		Ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах	Уурхайн ажилчид	71	-	Үйл ажиллагааны зардлаар	Жил бүр	
<b>Нийт</b>						<b>1,200,000</b>		

### 5.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 2

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг / 2025 он /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлаас үүсэх орчны бохирдол	Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах, ангилсан хаягдлыг агуулах хогийн савнууд суурилуулж, тэмдэгжүүлэх	Хог хаягдал	-			Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн үйл ажиллагааны явцад	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/ -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага

		Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих, барьсан хашааг арчлах	Хог хаягдал	-	Дотоод төлөвлөлтөөр		Жил бүр
		Хог хаягдлыг орон нутгаас заасан хогийн төвлөрсөн цэгт цаг тухай бүрт тээвэрлүүлэх, орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах				360,000	Жил бүр
3	Аюултай хог хаягдал	Шатах тослох материалын үлдэгдлийг зориулалтын саванд цуглуулж хадгалан гэрээт компанид нийлүүлэх	Аюултай хог хаягдал	ш	Гэрээт компанид нийлүүлэх		Жилд 1 удаа
4		Аюултай хог хаягдал хадгалах сав баглаа боодол стандартын шаардлага хангасан хаяг шошготой байх		-	Дотоод төлөвлөлтөөр		Тогтмол
<b>Нийт</b>					<b>360,000</b>		

### 5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт “Шинээгийн ам болон жалга-3”-ыг олборлохоор “Ирмүүн босго” ХХК-иас явуулж байгаа уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт, хэмжилт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Ирмүүн босго” ХХК хариуцах шаардлагатай.

#### Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал /төгрөг/ Эхний жил	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд доод хязгаар
Агаарын орчин								

1	TSP	мкгр/м <sup>3</sup>	- Зам - Уурхай	Жилд 1 удаа	24 цагийн хэмжилтийг хийж, цаг агаарын үзүүлэлтийн хамт тооцоход 150.0 мян.төг 2 цэг*150.0	300,000.0	-MNS 3384:82 агаар мандлын сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS 5585:2008 агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ техникийн шаардлага	
2	PM <sub>10</sub>	мкгр/м <sup>3</sup>						24 цагийн дундаж-100 Жилийн дундаж-500
3	PM <sub>2.5</sub>	мкгр/м <sup>3</sup>						24 цагийн дундаж-50 Жилийн дундаж-25
4	NO <sub>2</sub> / азотын давхар исэл	мкгр/м <sup>3</sup>						20 минутын дундаж-85 24 цагийн дундаж -40 Жилийн дундаж-30
5	SO <sub>2</sub> / хүхэрлэг хий	мкгр/м <sup>3</sup>						10 минутын дундаж-500 20 минутын дундаж -450 4 цагийн дундаж -20 Жилийн дундаж-10
6	CO/ нүүрстөрөгчийн дутуу исэл	мкгр/м <sup>3</sup>						30 минутын дундаж - 60000 1 цагийн дундаж- 30000 8 цагийн дундаж-10000
Хөрс								
1	pH		- Шинээгийн ам орд орчим - Жалга 3 орд орчим - Кемп	Жилд 2 удаа	/Хөрсний химийн шинжилгээ 1дээж- 25.0₮, 3 цэг * 2 удаа	150,000.0	-MNS 3298:91 “хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага” -MNS 5850:2008 хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн хэмжээ	
2	CaCO <sub>3</sub>	%						Хэмжилтээр
3	EC2.5	dS/m						Хэмжилтээр
4	Ялзмаг	%						Хэмжилтээр
5	Элс	%, мл-ээр						2-0,05
6	Тоос	%, мл-ээр						0,05-0,002
7	Шавар	%, мл-ээр						<0,002
8	Cd / кадми	мг/кг						3
9	Cu/зэс	мг/кг						100
10	As / хүнцэл	мг/кг						0,05
11	Cr / хром	мг/кг						150
12	Zn /цайр	мг/кг						300
13	Co /кобальт	мг/кг						50
14	Ni / никель	мг/кг						150

15	Pb / хар тугалга	мг/кг						100
16	Нийт бичил биетийн тоо	1см <sup>3</sup>						100
Ус								
1	pH							3-7
2	Эрдэжилт	мг/л						1000
3	Хатуулаг	мг-экв/л						7
4	SO4 / сульфат	мг/л						500
5	Cl / хлорид	мг/л						Зхийх50
6	Ca / кальци	мг/л						100
7	NH4 / аммони	мг/л						1,5
8	NO2 / нитрит	мг/л						3
9	NO3 / нитрат	мг/л						50
10	Cd / кадми	мг/л	- Худаг - Тунаах нуур	Жилд 2 удаа	/Усны ерөнхий шинжилгээ 25.0 ₮ /2 цэг*2удаа/ Хүнд металлын шинжилгээ 55.0 /2цэг*2удаа/	320,000.0	-MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус- Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS /ISO/ 5667- 11:2000 Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж, -MNS 900:2009, Хүний унд ахуйн зориулттай усны чанарын норм, -MNS6148-2010, “Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”	0,003
11	Cu / зэс	мг/л						2,0
12	As / хүнцэл	мг/л						0,01
13	Cr / хром	мг/л						0,05
14	Zn / цайр	мг/л						5,0
15	Co / кобальт	мг/л						0,1
16	Ni / никель	мг/л						0,02
17	Pb / хар тугалга	мг/л						0,01
18	Fe / төмөр	мг/л						0,3
19	Нийт бичил биетийн тоо							100
<b>Нийт</b>								<b>770,000.0</b>

### 5.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	MNS 5002 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
2	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг зохион байгуулах	Уурхайн ажилчдад	Дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	

3	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн удирдлага	Дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	Шуугианы норм, аюулгүй ажиллагаа-ны ерөнхий шаардлага -MNS 12.4. 005 - 1985 Хөдөлмөр хамгаалал. Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд
4	Байгаль орчны аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Уурхайн удирдлага	5,000,000	2 жилд 1 удаа	
5	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх	Уурхайн удирдлага	2022 онд хийгдсэн.	5 жилд 1 удаа	
6	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн ажилчдад	Дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	
7	Ажилчдыг хөдөлмөр хамгаалал хувцас хэрэглэлээр хангах	Уурхайн ажилчид	Үйл ажиллагааны зардал	ХАБЭА-ны төлөвлөлтөөр	
8	Ажиллагсдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Уурхайн ажилчид	Үйл ажиллагааны зардал	ХАБЭА-ны төлөвлөлтөөр	
<b>Нийт</b>			<b>5,000,000.0</b>		

### 5.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

Хүснэгт 16. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн Агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зардал	Зохион байгуулах газар
1	Сумын иргэд	Тайлагнах хэлэлцүүлэх	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүр	Байгаль хамгаалах сөрөг нөлөөллийг бууруулах талаар санал авах, шинэлэг санал, санаачилга	Шаардлагатай тохиолдолд	Заамар сумын иргэдийн танхим
2	Шаардлагатай тохиолдолд сонирхогчид, байгаль орчны төрийн бус байгууллага			Шаардлагатай тохиолдолд		Шаардлагатай тохиолдолд	
3	Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд	Хэлэлцүүлэх	БОМТ-ий хэрэгжилтийн талаар Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах ба эдийн засгийн алдагдал болон бусад мэдээллийг	Хагас жил тутамд	Цаашид анхаарах асуудал	Дотоод төлөвлөлтөөр	Сум багийн иргэдийн нийтийн хуралд
4	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутамд	Цаашид анхаарах асуудал	Дотоод төлөвлөлтөөр	Засаг даргын тамгын газар
5	БОАЖЯ	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлын биелэлтийг тайлагнах	Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө батлагдсаны дараа	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	Дотоод төлөвлөлтөөр	БОАЖЯ-нд



### 5.12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

“Ирмүүн босго” ХХК нь 2025 оны БОМТ-г БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2025 онд БОМТ-ний хэрэгжилтэнд нийт 65.08 сая.төг төлөвлөлөө

*Хүснэгт 17. 2025 оны БОМТ-ний нийт зардал*

№	Арга хэмжээ	Зардал /Төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	500,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	47,254,286
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
4	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд	10,000,000
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,200,000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	360,000
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5,000,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	770,000
<b>Нийт дүн</b>		<b>65,084,286</b>

## ДҮГНЭЛТ

“Ирмүүн босго” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Шинээгийн ам болон жалга-3”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь өмнөх жилүүдэд бүрэн хүчин чадлаар ажиллаж чадаагүй, ордын нөөцийг бүрэн ашиглаж дуусаагүй байгаа тул 2025 онд уурхайн хаалт хийгдэхгүй. Иймд төслийн БОННУ-ний тайлангийн хаалтын өмнөх жилийн менежментийн төлөвлөгөөг урьтал болгон 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээнүүдийг тухай бүрт хэрэгжүүлж тухайн онд хийсэн ажлаа холбогдох газруудаар хянуулж батлуулах шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2025 онд нийт 65.08 сая.төг зарцуулахаар төлөвлөлөө. Үүнийг үндэслэн “Ирмүүн босго” ХХК нь Төрийн сангийн БО нөхөн сэргээлтийн барьцааны дансанд 32,542,143 төгрөгийг байршуулсан байна.

“Ирмүүн босго” ХХК нь байгалийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж зэргийг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй.

Мөн олборлолтонд өртсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих дүрэм, журмын дагуу чанартай гүйцэтгэх шаардлагатай байна.